



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭДИЙН ЗАСГИЙН ТЭНХИМ

“ЭКОНОМИКСИЙН ЦАГААН ТОЛГОЙГ ХЭН САЙН МЭДЭХ ВЭ?”


ЭКОНОМИКСИЙН УЛСЫН ХИП ОЛИМПИАДЫН ТЕСТ

2017-05-13

Хугацаа 60 минут

- Пүүс орлох бүтээгдэхүүн олонтой X бараа, хэрэглэгчийн орлогод бага байр эзэлдэг Y бараа үйлдвэрлэдэг. R_x, P_y хоёул буурсан бол борлуулалтын орлого R_x, R_y яаж өөрчлөгдөх вэ?
 - R_x өссөн, R_y буурсан
 - R_x, R_y хоёул буурсан
 - R_x буурсан, R_y өссөн
 - R_x, R_y хоёул өссөн
- Харандааг төгс өрсөлдөөнт зах зээлд үйлдвэрлэдэг ба зах зээлийн эрэлт нь $Q=100-p$. Үйлдвэрлэгч бүр ижил $AC=4+(2-q)^2$ урт хугацааны дундаж зардалтай бол зах зээлийн үнэ хэд болох вэ?
 - 24
 - 0
 - 4
 - өгөгдөл дутуу тул тооцох боломжгүй
- Харандааг төгс өрсөлдөөнт зах зээлд үйлдвэрлэдэг ба зах зээлийн эрэлт нь $Q=100-p$. Үйлдвэрлэгч бүр ижил $AC=4+(2-q)^2$ урт хугацааны дундаж зардалтай бол урт хугацааны тэнцвэр тогтох үед зах зээлд хэдэн үйлдвэрлэгч ажиллах вэ?
 - 48
 - 19
 - 96
 - өгөгдөл дутуу тул тооцох боломжгүй

Зурагт өгөгдсөн өгөгдлийг ашиглан 4-6-р асуултад хариул.



- Монополь бүтээгдэхүүнээ нэг үнээр худалддаг бол хамгийн их ашиг нь хэд байх вэ?
 - 45
 - 126
 - 135
 - 90
- Монополь үйл ажиллагаа явуулах үеийн нийгмийн алдагдал ойролцоогоор хэд вэ?
 - 18
 - 16.5
 - 9
 - 1.5
- Төгс үнийн ялгаварлал явуулсан бол монополийн ашиг хэд байх вэ?
 - 180
 - 189
 - 63
 - 135

- Төгс өрсөлдөөнт үйлдвэрлэгчийн нийлүүлэлт нь
 - $P=MC$ байхаар үйлдвэрлэлээ сонгох тул MC -ийн муруй байна
 - $P < AC$ үед эдийн засгийн ашиггүй тул AC -ийн буурах хэсэг байна
 - $MR=MC$ байхаар үйлдвэрлэлээ сонгох тул MR -ийн муруй байна
 - $P < AVC$ үед бүтээгдэхүүн үйлдвэрлэхгүй тул AVC -ийн өсдөг хэсэг байна

- Монополийн эрэлтийн функц нь $Q = 100 - 2p$, нийт зардлын функц нь $450 + 20Q$ бол пүүсийн хамгийн их ашигтай ажиллах үеийн үнэ болон ашиг хэд вэ?
 - 35, -100
 - 35, 0
 - 30, 0
 - 30, 100
- Дараах тохиолдлуудын алинд нь хүчин зүйлийн эрэлт зайлшгүй өсөх вэ?
 - Хүчин зүйлийн ахиу бүтээгдэхүүн өсч, эцсийн бүтээгдэхүүний үнэ буурах, хослох нөөцийн үнэ буурах
 - Хүчин зүйлийн ахиу бүтээгдэхүүн буурч, эцсийн бүтээгдэхүүний үнэ өсөх, хослох нөөцийн үнэ буурах
 - Хүчин зүйлийн ахиу бүтээгдэхүүн өсөх, эцсийн бүтээгдэхүүний үнэ өсөх, хослох нөөцийн үнэ буурах
 - Хүчин зүйлийн ахиу бүтээгдэхүүн өсөх, эцсийн бүтээгдэхүүний үнэ өсөх, хослох нөөцийн үнэ өсөх
- Монопони компанийн хөдөлмөрийн эрэлтийн функц $W=10-L$ (W - нэг цагийн цалин, L - хөдөлмөрийн тоо хэмжээ) гэж өгөгджээ. Монопони компанийн хөдөлмөрийн нийлүүлэлт $W=0.5L$ гэж өгөгдсөн бол хичнээн ажилчин хөлслөн авах вэ? Цалин хэд байх вэ?
 - $L=5; W=5$
 - $L=5; W=2.5$
 - $L=2.5; W=5$
 - $L=2.5; W=2.5$
- Хөдөлмөрийн ТӨЗЗ нь монопони зах зээлтэйгээ харьцуулахад
 - Илүү олон ажилчин авч, илүү өндөр цалин төлөх болно
 - Цөөн ажилчин авч, илүү цалин төлөх болно
 - Цөөн ажилчин авч, бага цалин төлөх болно
 - Олон ажилчин авч, бага цалин төлөх болно
- Бүтээгдэхүүний болон хөдөлмөрийн зах зээл нь ТӨЗЗ байдаг. Хөдөлмөр болон нийт үйлдвэрлэл нь дараах хүснэгтээр өгөгджээ. Хэрвээ бүтээгдэхүүний үнэ 13 төгрөг бөгөөд цалин 780 төгрөг бол пүүсүүд нийт хичнээн ажилчин хөлслөн авах вэ?

Хөдөлмөрийн хэмжээ (L)	Нийт бүтээгдэхүүн (Q)
5	800
6	900
7	990
8	1070
9	1140
10	1200
11	1250

- $L=8$
- $L=9$
- $L=10$
- $L=11$

13. “А” компаний хөрөнгө оруулалтанд шаардлагатай байгаа зээлийн хэмжээ 40 сая төгрөг, зээлээ төлж дуусах хугацаа 3 жил, зээлийн хүү тогтмол 10% бөгөөд жил бүрийн хүлээгдэж буй ашгийн хэмжээ дараах хүснэгтэд өгөгджээ. Хөрөнгө оруулалтын өнөөгийн үнэ цэнийг ол.

Жил	Хүлээгдэж буй ашгийн хэмжээ (сая төгрөг)
1	15
2	16
3	18

- a. $PV=40$ сая
 b. $PV=40.09$ сая
 c. $PV=40.38$ сая
 d. $PV=38.40$ сая
14. Дараахийн аль нь үнэн бэ?
 a. Газрыг орлох өөр хүчин зүйл байхгүй, газрыг нэг орон зайгаас нөгөөд шилжүүлэх боломжгүй, газрын хэсэг бүр чанараараа төстэй.
 b. Газрыг орлох өөр хүчин зүйл байгаа, газрыг нэг орон зайгаас нөгөөд шилжүүлэх боломжгүй, газрын хэсэг бүр чанараараа харилцан адилгүй.
 c. Газрыг орлох өөр хүчин зүйл байхгүй, газрыг нэг орон зайгаас нөгөөд шилжүүлэх боломжтой, газрын хэсэг бүр чанараараа харилцан адилгүй.
 d. Газрыг орлох өөр хүчин зүйл байхгүй, газрыг нэг орон зайгаас нөгөөд шилжүүлэх боломжгүй, газрын хэсэг бүр чанараараа харилцан адилгүй.
15. Хэрэв татварын түвшинг эрс нэмэгдүүлбэл дараахь сценариудаас аль нь илрэх вэ?
 a. Хэмжигдсэн ДНБ эдийн засгийн үйл ажиллагааны бодит дүнтэй харьцуулахад буурна
 b. Хэмжигдсэн ДНБ эдийн засгийн үйл ажиллагааны бодит дүнд ойртож очно
 c. Шинэ татварын орлого нь ЗГ-ын зарлагыг өсгөх боломж олгох тул тэр хэмжээгээр ДНБ өснө
 d. Хувийн хэрэглээ өснө харин ЗГ-ын зарлага буурна
16. Танай аав 1991 онд сарын 1400 төгрөгийн цалин авч байжээ. 1991 онд ХҮИ 152.7 ба 2015 онд 40787.6 байсан бол аавтайгаа адилхан бодит цалинтай байхын тулд чи 2015 онд сард хэдийг олох ёстой вэ?
 a. 1400
 b. 213780
 c. 373953.1
 d. 571026.4

Дараах хүснэгтийг ашиглан асуулт 17, 18-д хариул.

Хувийн хэрэглээний зардал	9000 тэрбум ₮
Хувь хүний орлогын татвар	1800
ЗГ-ын хэрэглээ	3000
ЗГ-аас олгодог хүүхдийн мөнгө	2000
Хүүгийн орлого	600
Экспорт	400
Импорт	750
Элэгдэл	600
Цэвэр хөрөнгө оруулалт	1400
Гадаадынхны цэвэр орлого	900
Шууд бус татвар	800

17. Энэ улсын ДНБ хэд вэ?
 a. 12.25 их наяд ₮
 b. 13.05 их наяд ₮
 c. 13.65 их наяд ₮
 d. 14.4 их наяд ₮
18. Энэ улсын нийт хөрөнгө оруулалтыг ол.
 a. 1400 тэрбум ₮
 b. 2200 тэрбум ₮
 c. 2000 тэрбум ₮
 d. 1200 тэрбум ₮
19. Та 100 ширхэг Говийн хувьцааг ширхэгийг нь 13500 төгрөгөөр худалдаж аваад арилжааны шимтгэл 27000 төгрөг төлжээ. Энэ шилжүүлэг ДНБ-д ямар хувь нэмэр оруулах вэ?
 a. 0
 b. 27000₮
 c. 1350000₮
 d. 1377000₮

Дараах хүснэгтийг ашиглан асуулт 20, 21-д хариул.

	Нэрлэсэн ДНБ (Тэрбум ₮)	ДНБ-ий дефлятор (1995=100)	Бодит ДНБ (1995 оны үнээр зэрэгцүүлсэн тэрбум ₮)	Нэрлэсэн ДНБ-ий өсөлт	ДНБ-ий дефляторын өсөлт	Бодит ДНБ-ий өсөлт
1990	5803	86.5	6709	5.7%	3.8%	1.8%
1991	5985	89.7		3.2%	3.7%	

20. 1991 онд бодит ДНБ хэдэн хувийн өсөлттэй байсан бэ?
 a. 0.54%
 b. -0.54%
 c. 1%
 d. -1%
21. Хэрэв 1991 онд хүн амын өсөлт 1% байсан бол нэг хүнд ногдох нэрлэсэн ДНБ-ий өсөлтийг ол.
 a. 2.2%
 b. 4.2%
 c. 2.8%
 d. Өгөгдөл хангалтгүй
22. 1990-ээд оны сүүлээр болсон Азийн санхүүгийн хямралын улмаас азийн улсуудын орлого буурсан нь худалдааны түнш Европын ДНБ болон үнийн түвшинд ямар нөлөө үзүүлсэн байж болох вэ?
 a. Европын бодит ДНБ болон үнийн түвшин аль аль нь буурна
 b. Европын бодит ДНБ болон үнийн түвшин аль аль нь өснө
 c. Европын бодит ДНБ буурч харин үнийн түвшин нь өснө
 d. Европын бодит ДНБ өсч харин үнийн түвшин нь буурна
23. Дараах үйл явдлуудын аль нь эдийн засгийн урт хугацааны нийт нийлүүлэлтийн муруйг шилжүүлэх вэ?
 a. Технологийн дэвшил
 b. Хөдөө аж ахуйн салбарын хувьд цаг агаарын таагүй нөхцөл байдал үүсэх

- c. Хүлээгдэж буй инфляцийн түвшин өсөх
 - d. Хөрөнгө оруулалтын түвшин буурах
24. Эрэлтийн шокийн улмаас бүтээгдэхүүн үйлчилгээний зах зээлийн үнийн түвшин хүлээгдэж байсан түвшингээсээ өндөр болсон бол үйлдвэрлэл нь
- a. Урт хугацааны потенциал түвшин дээрээ байна
 - b. Урт хугацааны потенциал түвшингээсээ бага байна
 - c. Урт хугацааны потенциал түвшингээсээ их байна
 - d. Хүлээгдэж буй инфляцийн түвшингээс цэвэр экспортыг хассантай тэнцүү байна
25. Чи мөнгө зээлдүүлэхээр төлөвлөж байгаа бол дараах нөхцлүүдийн аль нь чамд хамгийн таатай нь байх вэ?
- a. Нэрлэсэн хүү 5% бөгөөд үнийн түвшин ирээдүйд тогтвортой байхаар хүлээгдэж байгаа
 - b. Нэрлэсэн хүү 9% бөгөөд хүлээгдэж буй инфляцийн түвшин 7% байгаа
 - c. Нэрлэсэн хүү 4% бөгөөд хүлээгдэж буй инфляцийн түвшин 1% байгаа
 - d. Нэрлэсэн хүү 25% бөгөөд хүлээгдэж буй инфляцийн түвшин 22% байгаа
26. Дараах хүснэгтэнд өгөгдсөн мэдээллийг ашиглан асуултанд хариулна уу?

	Ажиглагдсан ДНБ (2000 оны үнээр, тэрбум доллароор)	Потенциал ДНБ (2000 оны үнээр, тэрбум доллароор)	Үнийн түвшин (ДНБ дефлятор)	Ажилгүйдлийн түвшин
2009	6,754	6,754	95	4.9
2012	8,590	7,540	100	4.0
2015	10,900	11,790	122	7.2

- Энэ эдийн засагт өгөгдсөн онуудад ажилгүйдэл нь ямар байсан бэ?
- a. 2009 онд хэвийн, 2012 онд бүтцийн, 2015 онд шилжилтийн ажилгүйдэлтэй байсан.
 - b. 2009 онд хэвийн, 2012 онд хэт ажил эрхлэлттэй, 2015 онд мөчлөгийн ажилгүйдэлтэй байсан.
 - c. 2009 болон 2012 онд мөчлөгийн ажилгүйдэлтэй, 2015 онд хэвийн ажилгүйдэлтэй байсан.
 - d. Бүх онуудад хэвийн ажилгүйдэлтэй байсан.
27. Өмнөх асуултын хүснэгтэнд өгөгдсөн мэдээллээр энэ эдийн засаг нь аль онд урт хугацааны тэнцвэртэй байна вэ?
- a. 2009
 - b. 2012
 - c. 2015
 - d. Дээрх бүгд зөв
28. Дараахаас аль нь Кейнсийн загварын хамгийн гол үндсэн ойлголт вэ?
- a. Үйлдвэрлэл болон үнийн өөрчлөлт нь, ялангуяа урт хугацаанд макро эдийн засгийн зохицох процесст гол үүрэг гүйцэтгэдэг
 - b. Үйлдвэрлэл эрэлтээ бий болгодог учраас ерөнхий бүтээгдэхүүн үйлчилгээний нийт эрэлтээс хэтэрсэн үйлдвэрлэл байх боломжгүй.
 - c. Нийлүүлэлтэнд гарч байгаа өөрчлөлт хэр зэрэг хариу үйлдэл үзүүлдэх нь ашиглагдахгүй байгаа нөөцтэй шууд хамааралтай байна.
 - d. Нийт эрэлтэнд гарч байгаа хэлбэлзэлүүд нь бизнесийн орчны тогтворгүй байдлын хамгийн чухал потенциал эх үүсвэр байдаг.
29. Эдийн засаг уналтанд орж байх үед автомат тогтворжуулагч дараахийг бий болгодог.
- a. Өндөр татвар

- b. Дискрет бодлогоор ЗГ-ын зардлыг нэмэгдүүлэх
 - c. Төсвийн алдагдлыг нэмэгдүүлэх
 - d. Төсвийн илүүдлийг нэмэгдүүлэх
30. Кейнсийн бизнесийн мөчлөгийн эсрэг (countercyclical) төсвийн бодлого нь дараахыг санал болгодог.
- a. Хэрвээ эдийн засаг бүрэн ажил эрхлэлтээс бага түвшинд ажиллаж байгаа бол төсвийн алдагдал байх хэрэгтэй
 - b. Инфляцийн хэт өсөлттэй байгаа үед төсвийн алдагдал төлөвлөгдсөн байх ёстой
 - c. Хэрвээ үндэсний өр эдийн засгаас илүү хурдтайгаар өсөж байгаа бол төсөв тэнцвэржсэн байх ёстой
 - d. Төсөв үргэлж тэнцвэржсэн байх ёстой
31. Дараах шалтгааны улмаас Кейнсийн макро эдийн засгийн загвар Дэлхийн II дайны дараах хэдэн арван жилд маш алдартай, түгээмэл хэрэглэгддэг байсан.
- a. Дайн дууссаны дараах эдийн засгийн хүчтэй сэргэлт
 - b. 1950-аад оны инфляцийн өндөр түвшин
 - c. 1930-аад оны сунжирсан ажилгүйдэл
 - d. Их Хямралын үеийн хөрөнгө оруулалтын өндөр түвшин
32. Ж.М. Кейнс болон түүний дагалдагчид Их Хямрал нь дараахын шууд үр дүн байсан гэж баталдаг.
- a. Хэт их ЗГ-ын зардал
 - b. Их хэмжээний төсвийн алдагдал
 - c. Холбооны Нөөцийн Сангийн гажуудсан мөнгөний бодлого
 - d. Бүтээгдэхүүн, үйлчилгээнд гаргасан нийт зардал хангалтгүй байсан
33. Кейнсийн үзлээр, хэрвээ бодлого боловсруулагчид эдийн засаг уналтанд орчихсон гэж бодож байгаа бол дараахиас аль нь илүү тохиромжтой бодлого вэ?
- a. ЗГ-ын зардлын бууралт
 - b. Зээлээр санхүүжүүлэгдэх ЗГ-ын зардлын өсөлт эсвэл татварын бууралт
 - c. Төсвийг тэнцвэржүүлэх
 - d. Татварыг нэмэгдүүлэх
34. Бизнесийн мөчлөг гэдэг нь
- a. Бодит ДНБ-ий потенциал ДНБ-ээс хэлбэлзэх хэлбэлзэл
 - b. Нэрлэсэн ДНБ-ий бодит ДНБ-ээс хэлбэлзэх хэлбэлзэл
 - c. Эдийн засгийн үйл ажиллагааны сэргэлтийн үе
 - d. Инфляци, ажилгүйдэл хоёр зэрэг өсөх үзэгдэл
35. $C = 700 + 36DI^{0.5}$, орлого 400 байх үеийн ахиу хэрэглэх хандлагыг ол.
- a. 0.36
 - b. 0.9
 - c. 0.5
 - d. 1
36. Үнийн түвшин буурч байгаа бол бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авахад шаардлагатай төгрөгийн хэмжээ
- a. Нэмэгдэнэ. Учир нь төгрөгийн үнэ цэнэ өсөх тул
 - b. Нэмэгдэнэ. Учир нь төгрөгийн үнэ цэнэ буурах тул
 - c. Буурна. Учир нь төгрөгийн үнэ цэнэ өсөх тул
 - d. Буурна. Учир нь төгрөгийн үнэ цэнэ буурах тул

37. Эдийн засгийн хямралын үед арилжааны банкууд илүүдэл нөөцийг ердийн үесээ илүү их байршуулсан бол энэ нь
- Мөнгөний үржүүлэгчийг өсгөж улмаар мөнгөний нийлүүлэлтийг өсгөдөг
 - Мөнгөний үржүүлэгчийг бууруулж улмаар мөнгөний нийлүүлэлтийг бууруулдаг
 - Мөнгөний үржүүлэгчид нөлөөлөхгүй боловч мөнгөний нийлүүлэлтийг өсгөдөг
 - Мөнгөний үржүүлэгчид нөлөөлөхгүй боловч мөнгөний нийлүүлэлтийг бууруулдаг

38. Нэгэн банкны дансны мэдээлэл дараах хүснэгтэд өгөгджээ. Дулмаа энэ банкинд 500000 төгрөгийн хадгаламж нээсэн бол энэхүү банкны заавал байлгах нөөц хэд болох вэ?

Актив		Пассив	
Заавал байлгах нөөц	₮30 000	Татан төвлөрүүлсэн хөрөнгө	₮100 000
Зээл	₮70 000		

- 150 000
 - 180 000
 - 450 000
 - 500 000
39. Бүрэн хүлээгдэж байсан инфляцийн зардлуудын нэг нь
- Баялгийг зээлүүлэгчээс зээлдэгчид шилжүүлнэ
 - Баялгийг зээлэгчээс зээлдүүлэгчид шилжүүлнэ
 - Цэсний зардлыг ихэсгэнэ
 - Үнэ эдийн засагт дохионы үүрэг гүйцэтгэхээ болино
40. Хүлээгдээгүй инфляцийн зардлуудын нэг нь
- Баялгийг зээлүүлэгчээс зээлдэгчид шилжүүлнэ
 - Баялгийг зээлэгчээс зээлдүүлэгчид шилжүүлнэ
 - Цэсний зардлыг бууруулна
 - Мөнгөний худалдан авах чадварыг нэмэгдүүлнэ
41. Бүтцийн ажилгүйдэл гэдэг нь
- Барилгын салбарт ажил эрхлэлт хангалтгүй байх
 - Ажлын байрны тоо буурах
 - Ажилтны ур чадварт тохирсон ажлын байр олдохгүй байх
 - Ажлын байр хангалттай байгаа хэдий ч ажиллах хүн ховор байх
42. Бизнесийн мөчлөгийн тэлэлтийн үед дараахийн аль нь ажиглагдах вэ?
- Бодит ДНБ өсөөд, ажилгүйдэл буурна
 - Бодит ДНБ буураад, инфляцийн түвшин өснө
 - Зээлийн хүү өсөөд, дампуурах бизнесийн тоо өснө
 - Инфляцийн түвшин өсөөд, ажил эрхлэлт буурна
43. Дараахаас аль нь албан ёсоор ажилгүйдэлд тооцогдох вэ?
- Долоо хоногт нэг өдөр цагийн багш хийдэг сургуулийн захиргааны ажилтан захиргааны бүтэн цагийн ажил хайж байгаа
 - Нэгэн математикч сүүлийн 4 сар ажил хайгаад олдоогүйн улмаас докторын сургалтанд элссэн
 - 60 настай хуучин гангийн үйлдвэрийн ажилладаг байсан ажилчин ажиллах сонирхолтой хэдий ч ажил идэвхтэй хайхаа больсон
 - Дээрхийн аль нь ч ажилгүйдэлд тооцогдохгүй
44. Хэвийн үйл ажиллагаатай байгаа динамик эдийн засагт
- Ажилгүйдлийн түвшин тэгтэй тэнцүү байх ёстой

- Бүтцийн болон шилжилтийн хүчин зүйлстэй холбоотой бага зэрэг ажилгүйдэлтэй байж болно
- Эдийн засгийн халалтын үед маш их ажилгүйдэлтэй болно
- Ажил эрхлэлт болон хүн амын харьцаа 100% болох ёстой

45. Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) өсөж байгаа үед дундаж өрх
- Амьжиргааны түвшингээ хэвээр хадгалахын тулд илүү их мөнгө зарцуулах хэрэгтэй
 - Амьжиргааны түвшингээ хэвээр хадгалахын тулд бага мөнгө зарцуулах хэрэгтэй
 - Амьжиргааны түвшинд нөлөөлөхгүй
 - Хадгаламж хийх замаар өсөж буй үнийн түвшингийн нөлөөг саармагжуулна
46. ХҮИ-г тооцоход кофе нь цайнаас илүү их жин эзэлдэг бол
- Хэрэглэгчид цайнаас илүү кофег их худалдан авдаг
 - Кофе цайнаас илүү үнэтэй
 - Кофе үйлдвэрлэх нь цай үйлдвэрлэхээс илүү зардалтай
 - Дундаж хэрэглэгчдийн хувьд кофе нь цайг бодвол хэрэглэхэд илүү хялбар
47. ХҮИ нь амьжиргааны өртгийн хэмжүүр болохын хувьд зарим нэг дутагдалтай талууд байдгийн нэг нь
- Хэрэглэгчдийн орон сууцны зарлагыг тооцож чаддаггүй
 - Хэрэглэгчдийн хүнс, хувцас болон цахилгаан эрчим хүчний хэрэглээг зөвхөн тооцдог
 - Хэрэглэгчид орлогын ихэнх хувиа зарим нэр төрлийн бараанд зарцуулаад бага хувийг нь өөр төрлийн бүтээгдэхүүнд зарцуулдгыг тооцдоггүй
 - Шинэ бүтээгдэхүүн бий болохыг тооцдоггүй
48. Дорж Кола болон үс хэрэглэдэг. Кола үнэтэй болсон учраас тэрээр өөр ундаа хэрэглэх болжээ. Энэ үед ХҮИ нь дараах үр дүнд хүргэнэ.
- Амьжиргааны зардлыг хэт багасгаж харагдуулна
 - Амьжиргааны зардалд огт өөрчлөлт ороогүй гэж харагдуулна
 - Амьжиргааны зардалтай энэ нь огт хамааралгүй үзэгдэл
 - Амьжиргааны зардлыг хэт өсгөж харагдуулна
49. Хэрэв сангийн бодлогоор дамжуулан эдийн засагт тогтворжуулах нөлөө үзүүлэх гэж байгаа бол энэ бодлого нь
- Тэлэх бодлого байх ёстой
 - Хязгаарлагдмал байх ёстой
 - Тохиромжтой цаг хугацааг сонгож хэрэгжих ёстой
 - Төсвийн алдагдлыг тэнцвэртэй байлгах ёстой
50. Засгийн газрын зарлагыг нэмэгдүүлснээр төсөв алдагдалтай байгаа бол энэхүү алдагдлыг хаанаас санхүүжүүлэх вэ?
- Татварын дараах орлогыг өсгөх замаар санхүүжүүлнэ
 - Төв банк мөнгө хэвлэх замаар санхүүжүүлнэ
 - Засгийн газраас бонд гаргах замаар санхүүжүүлнэ
 - Төсвийн алдаглыг хууль ёсоор хариуцдаг парламентийн гишүүдийн санхүүгийн хөрөнгөөр санхүүжүүлнэ